



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 06 өдөр

Дугаар А/355

Мандалговь

Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 заалт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/190, А/280 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам”-ын 3.8.1, Журамд өөрчлөлт оруулах тухай 2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/70, А/80 дугаар хамтарсан тушаалын 1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гэмт хэрэг зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэн, мөрдөн шалгагдаж байгаа эсхүл гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн хүүхдэд хууль зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Хорооны даргад: - Аймгийн Засаг даргын орлогч

Нарийн бичгийн даргад : - Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга

Гишүүдэд:

- Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга
- Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
- Аймгийн Шүүхийн Тамгын газрын дарга
- Аймгийн Прокурорын газрын Ерөнхий прокурор
- Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга
- Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга
- Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга
- Аймгийн Цагдаагийн газрын дарга
- Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга

4822111180

- Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Зөвлөлийн нарийн бичгийн дарга
- Өмгөөлөгчдийн Холбооны аймаг дахь салбар
- Зөвлөлийн дарга (Зөвшилцсөнөөр)
- Сайнцагаан сумын Хүүхдийн элч
- "Гэрэлтдэг ертөнц" ТББ-ын тэргүүн

2. "Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам"-аар хүлээсэн чиг үүргээ бодитой хэргжүүлж, хүүхдийн эрхийг хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо (М.Анхбаяр)-нд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ